

БАРАА ХУДАЛДАХ БА ХУДАЛДАН АВАХ ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ АСУУДАЛД

*Ж.Оймандах**

Бараа худалдах ба худалдан авах олон улсын гэрээ нь гадаад худалдаанд голлох байр суурь эзэлдэг гэрээ бөгөөд экспорт ба импортын гэрээний бүлэгт хамаарагдана. Гадаад худалдаанд тус гэрээний харилцааг “Бараа худалдах ба худалдан авах олон улсын гэрээний тухай Венийн Конвенци”-оор (1980) ба улс орнуудын хууль зүйн актуудаар зохицуулдаг байна. Өнөөгийн байдлаар уг гэрээнд 51 улс нэгдсэн бөгөөд Монгол Улс 1997 онд нэгдэн оржээ.

Бараа худалдах ба худалдан авах гэрээ нь Олон улсын үүсмэл эрх зүйн хүрээнд хамрагдах бөгөөд дотоодын хуулиар зохицуулагддаг ижил төстэй гэрээ хэлцлүүдээс ялгагдана. Тиймээс түүний ойлголтыг тодорхойлох хэрэгтэй байдаг. Гэтэл олон улсын ямар нэгэн конвенци, эсвэл аль нэг улсын үндэсний хууль эрх зүйн актуудад бараа худалдах ба худалдан авах олон улсын гэрээний тухай ойлголтыг тодорхойлж өгөөгүй байна.

Дэлхийн II дайны өмнөх Иргэний эрх зүйг ижилсгэх, тайлбарлах, Ромын олон улсын институт (УНИДРУА) бараа худалдах ба худалдан авах гэрээний талаархи нэгдмэл материаллаг хэм хэмжээ хэлэлцэж Гаагын бага хурлын үеэр хэвлүүлсэн байна. Уг олон улсын гэрээний төсөлд тус гэрээний ойлголтыг дараахи байдлаар тодорхойлсон. Үүнд:

1-р зүйлд: Уг хууль үл хөдлөх эд хөрөнгийн зүйлсийг хамаарах ба арилжааны үйл ажиллагаагаа өөр өөр улсын нутаг дэвсгэр дээр явуулж байгаа талуудын хооронд байгуулах бөгөөд дараахи тохиолдолд хэрэглэнэ. Үүнд:

а) Хэрэв контракт байгуулах явцад нэг улсын нутаг дэвсгэрээс нөгөө улсын нутаг дэвсгэр лүү тээвэрлэлтийн зүйл шилжихэд зориулагдсан эд хөрөнгийг хөндөж байвал;

* МУИС-ийн ОУХС-ийн магистр багш

б) Хэрэв оферт ба акцентын актууд янз бүрийн улсуудын нутаг дэвсгэр дээр үйлдэгдэж байвал;

в) Хэрэв барааг хүлээлгэн өгөх явц оферт ба акцентын актуудыг үйлдсэн улсын нутаг дэвсгэрээс өөр улсад болох тохиолдолд хэрэглэнэ гэж заасан байна.

Өнөө үед УНИДРУА-гийн байр суурь нь олон улсын худалдааны гэрээний критерийн хувьд өөрчлөгдсөн. Тухайлбал, тус байгууллагаас хамгийн сүүлд боловсруулж гаргасан “Олон улсын харилцааны гэрээний зарчмууд” хэмээх томоохон төсөлд ямар нэгэн гадаад худалдааны гэрээний ойлголтыг тусгаагүй байна. Тэрээр боломжийн хирээр хэд хэдэн гадаад эдийн засгийн гэрээг гадаад элемент огт байхгүй гэрээнээс ялгахыг зорьсон байна. Тус олон улсын актанд тусгасан зарчмууд нь олон улсын гэрээ конвенцийн хууль зүйн үндэслэлгүй бөгөөд эдгээр нь эрх зүйн үндсэн эх сурвалж болохгүй юм.

Бараа худалдах ба худалдан авах олон улсын гэрээний талаар ярихдаа гадаад элемент агуулсан нэг улсаас дээш улсуудын үндэсний хилээр давсан олон улсын худалдааны сонирхлыг илэрхийлэх ямар нэгэн хэлцэл гэж явцуу ойлгож болохгүй. Энэ тухайд олон улсын хэм хэмжээг маш амжилттай нэгтгэсэн Бараа худалдах ба худалдан авах олон улсын гэрээний тухай Венийн конвенци батлагдан гарсан. Гэвч конвенцид мөн л уг гэрээний ойлголтыг тодорхойлолгүй, зөвхөн субъектуудын оролцох хүрээг заасан байна.

Уг конвенци өөр өөр улсад орших арилжааны нэгжүүдийн хооронд байгуулагдах олон улсын бараа худалдах ба худалдан авах гэрээнд дараахи тохиолдлуудад хэрэглэгдэнэ. Үүнд

А) хэрэв эдгээр улсууд зөвшилцөж буй улсууд болох тохиолдолд;

Б) хэрэв олон улсын үүсмэл эрх зүйн дагуу зөвшилцөж буй улсуудын эрх зүй хэрэглэгдэх тохиолдолд г.м.

Үүнийг тодорхой авч үзвэл бараа худалдах ба худалдан авах олон улсын гэрээний нэгэн шинж болох арилжааны нэгжүүд өөр өөр улсуудад байрлах ёстой байна. Энэ харилцааны талаар хэд хэдэн онол байдаг.

Л.А.Лунцийн үзэж байгаагаар “Гадаад эдийн засгийн хэлцэлд нэгээс багагүй субъект оролцож буй аль нэг тал нь гадаадынх (гадаадын иргэн эсвэл гадаадын хуулийн этгээд) байх ёстой. Ийм гэрээний агуулга нь барааг хилээр дамжуулан дотоодод оруулах ба гадаадад гаргах үйл ажиллагаанд оршино”¹ гэжээ. Т.Н.

¹ Л.А.Лунц *Международное частное право. Москва 1964*

Богуславский мөн энэ асуудлаар ижил бодол баримталж “Гадаад эдийн засгийн хэлцэлд манай номлолын дагуу нэг тал нь л гэхэд гадаадын иргэн, эсвэл гадаадын хуулийн этгээд байх ёстой”² гэсэн байна.

Т.Г.Розенберг бичихдээ “Гадаад худалдааны хэлцэлд экспорт ба импортын үйл ажиллагаа явагдах бөгөөд талууд нь янз бүрийн харьяалалтай байх ёстой”³ гэжээ.

Америкийн судлаач Фолсом бичихдээ “Бараа худалдах ба худалдан авах олон улсын гэрээ нь үндэсний хилээр гадагш гулган урсах харилцааг зохицуулах гэрээ бөгөөд түүгээрээ үндэсний худалдах ба худалдан авах гэрээнээс ялгагдана”⁴ гэсэн байна.

Дээрх судалгаануудаас үүдэн яагаад иргэд хувийн өмчлөлд өрөө авдаггүй, харин өөр өөр улсын нутаг дэвсгэр дээр орших аж ахуйн нэгжүүд өмчлөлдөө шилжүүлэн авдаг вэ гэсэн асуулт энд гарч ирдэг. Харин уг асуултанд Венийн конвенци хариулт өгдөг байна.

Тус конвенцийн 2-р зүйлд заасны дагуу шийдвэрлэсэн тус зүйлийн дагуу конвенцид хамаарагдахгүй худалдаанд хамаарах зүйлсийг жагсаасан байдаг. Үүнд:

- а) аукционоос;
- б) хууль зүйн акт гүйцэтгэх үед;
- в) фондыг хангах үнэт цаас болон эргэлтийн баримт бичиг ба мөнгө;
- г) хөлөг онгоц болон нисэх онгоц, мөн түүнчилэн хийн дэрэн дээрх усан онгоц;
- д) цахилгаан эрчим хүч тус тус бараа конвенцид хамаарагдахгүй гэж заажээ.

Үүнээс харахад Венийн конвенцид бүх л худалдах ба худалдан авах үйл ажиллагааг хамруулдаггүйг харж болно.

Дээрх судалгаануудаас үзэхэд бараа худалдах ба худалдан авах олон улсын гэрээний ойлголтыг судалгааны үүднээс тодорхойлж болно. Үүнд: бараа худалдах ба худалдан авах олон улсын гэрээгээр нэг улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж эрхэлдэг худалдагч, нөгөө улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж эрхэлдэг худалдан авагчийн өмчлөлд нэгээс дээш орны хилээр дамжуулан барааны эрхийг шилжүүлэх үүрэг хүлээнэ гэж болох юм.

² М.М.Богуславский *Международное частное право. Москва 2001*

³ М.Г.Розенберг *Международная купля-продажа товаров. Москва 1995*

⁴ R.H.Folsom, M.W.Gordon, J.A.Spanogle, *International business transactions in a nutshell, St. Paul, 1992*

International contract of sale of goods is the common civil transaction in the world of international trade. Therefore, we need to determine its law understanding not only in the national law system, but also in the international trade relations for further concluding mentioned transaction in foreign trade area correctly and profitable.